

Омнод Солонгос ба БНАСАУ Солонгосын хойгт энх тайвнаар зэрэгцэн орших, тогтонги байдлыг хангах боломжийг олох ёстой гэж Бээжинд БНХАУ-ын ГХ-ийн сайд Ян Зечи БНСолонгос улсын еронхийлогчийн онц эрхт толоологч Ким Му Соныг хвлээн авч уулзахдаа мэдэгдэв. БНСолонгос Улс, БНАСАУ-ын хоорондын харилцааг сайжруулахад чиглэгдсэн хүчин чармайлтыг хятадын тал дэмжиж байна гэж Ян Зечи уулзалтын үеэр онцлов. Хятад улс БНСолоногос Улстай харилцааг хөгжүүлэхийг их ач холбогдолтойд үзэж байна. Хамтын хүчин чармайлтын ачаар хоёр талын харилцаа илүү ондор түвшинд хүрнэ гэж сайд тэмдэглэн хэлжээ.